



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 07 өдөр

Дугаар А/625

Хэрлэн сум

Шинээр хамгаалалтын ойн зурвас  
байгуулах ажилд хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны аравдугаар хуралдааны “Гучин сая мод” хөтөлбөр, төлөвлөгөө батлах тухай 07 дугаар тогтоол, 2023 оны Хорьдугаар хуралдааны “Аймгийн 2023 оны төсвийн тодотгол батлах тухай” 07 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх хүрээнд хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, шинээр хамгаалалтын ойн зурвас байгуулах ажилд шаардагдах модны суулгац худалдан авахад 19,500,000 (арван есөн сая таван зуун мянга) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.


2. Шаардагдах хөрөнгийн зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрх хөрөнгийг 2023 оны аймгийн төсөвт тусгагдсаны дагуу Засаг дарга дансны төвлөрсөн арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2023  
оны 12 дугаар сарын 07-ны  
дугаар захирамжийн хавсралт

**ЗАРДЛЫН ТООЦОО**

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ ₮	Нийт үнэ ₮
1	Улиас	ш	3000	3,900	11,700,000
2	Хайлаас	ш	2000	3,900	7,800,000
	<b>Нийт дүн</b>				<b>19,500,000</b>